



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2018

Э-сонин

11-Р САР

64-р дугаар





Үнэт цаасны зах зээл

Зах зээлийн тойм

/2018.11.30-ны өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр

2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/

Хувьцаа /анхдагч/

Хувьцаа /хоёрдогч/

Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/

Компанийн бонд /анхдагч/

Компанийн бонд /хоёрдогч/

3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг

Хувьцаа /анхдагч/

Хувьцаа /хоёрдогч/

Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/

Компанийн бонд /анхдагч/

Компанийн бонд /хоёрдогч/

4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо

5,417,410,085.85

4,536,811,565.85

880,598,520

0

0

38,298,936

0

38,290,626


8,310

0


0

2,891


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	222
100% төрийн өмчит	19
Төрийн өмчийн оролцоотой	12
Хувийн өмчийн	119
I ангилал	13
II ангилал	42
III ангилал	167

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	61
Үүнээс: Брокер, Дилер	52
Андеррайтер	24
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны гишүүн компаниуд

/2018.11.30-ны байдлаар/

Симб ол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Ард капитал групп ХХК	21,792,175	1,196,196,722.86	21,655,401	1,103,473,321.34	2,299,670,044.20
2	Голомт Капитал ХХК	1,067,935	541,281,017.38	370,906	203,349,370.60	744,630,387.98
3	Ард секюритиз ХХК	569,708	412,157,528.47	349,014	239,165,152.18	651,322,680.65
4	БиДиСек ХК	1,895,112	154,833,460.31	447,330	277,891,024.65	432,724,484.96
5	Стандарт инвестмент ХХК	628,105	128,013,074.78	1,198,307	241,435,301.57	369,448,376.35
6	Новел инвестмент ХХК	1,393,781	117,124,162.56	1,516,923	247,650,840.00	364,775,002.56
7	Бумбат-Алтай ХХК	716,944	246,141,420.88	378,502	106,144,536.70	352,285,957.58
8	Ти Ди Би Капитал ХХК	575,804	171,635,788.44	732,722	161,187,449.53	332,823,237.97
9	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	2,967,819	235,070,028.00	3,220,456	239,209,583.44	474,279,611.44
10	Санар ХХК	2,619	855,350.00	283,735	168,173,518.00	169,028,868.00
11	БиДиСек ХК	390	218,340.40	1,499,224	159,404,907.80	159,623,248.20
12	Гаули ХХК	299,546	89,922,278.53	103,717	44,581,004.05	134,503,282.58
13	Тэсо инвестмент	54,959	30,703,493.00	62,540	89,102,696.40	119,806,189.40
14	Зэргэд ХХК	68,079	36,252,550.07	69,378	37,837,570.00	74,090,120.07
15	Монсек ХХК	14,495	15,750,193.80	59,414	34,567,273.50	50,317,467.30
16	Нэйшнл сэкюритис ХХК	1,943	45,542,600.00	1,653	613,075.00	46,155,675.00
17	Эм Ай Би Жи ХХК	2,962	6,526,260.00	75,875	22,330,177.50	28,856,437.50
18	Батс ХХК	151,996	12,410,410.00	20,909	14,344,032.00	26,754,442.00
19	Дэлгэрхангай секюритиз ХХК	4	70,000.00	103,183	26,555,636.90	26,625,636.90
20	Блүмбюри секюритис ХХК	6,765	5,677,687.00	41,924	20,062,666.89	25,740,353.89

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2018.11.30-ны байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт /%/
1	HBO	ХАЙ БИ ОЙЛ	21,596,107	1,058,608,378.99	53.00	42.00	4.00	8.16
2	APU	АПУ	773,758	449,595,452.77	600.00	560.00	-17.06	-2.90
3	LEND	ЛЭНДМН ББСБ	5,796,581	417,031,990.29	75.99	68.00	-3.41	-4.57
4	AIC	АРД ДААТГАЛ	435,236	323,941,985.97	800.00	706.00	71.32	10.14
5	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	38,512	187,004,162.00	5,040.00	4,550.00	-210.00	-4.28
6	GOV	ГОВЬ	5,319	175,055,620.00	34,300.00	31,800.00	-960.00	-2.83
7	ERDN	ЭРДЭНЭ ГЕСУРС	292,485	174,285,513.20	610.00	520.00	39.76	7.23
8	ADU	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	206,884	156,312,475.00	950.00	550.00	340.00	58.62
9	TTL	ТАВАН ТОЛГОЙ	15,522	108,359,230.00	7,800.00	6,200.00	-1,150.00	-15.03
10	JIV	ЖИНСТ-УВС	67,826	107,895,551.00	1,799.00	1,277.00	172.00	10.68
11	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	312,858	99,127,598.24	335.00	295.00	-18.00	-5.66
12	ITLS	АЙГҮҮЛС	801,157	88,884,661.58	121.00	105.00	-8.07	-6.83
13	RMC	РЕМИКОН	1,360,067	33,990,261.62	31.99	24.00	-6.10	-19.00
14	MNP	МОНГОЛ ШУУДАН	42,377	22,921,128.00	590.00	501.00	45.01	8.34
15	HGN	ХӨХ ГАН	270,895	19,387,894.00	90.00	70.00	-18.99	-20.20
16	MIB	МОНИНЖБАР	101,351	12,737,603.90	153.00	85.00	-90.00	-50.00
17	TCK	ТАЛХ ЧИХЭР	597	12,096,400.00	21,000.00	19,500.00	-1,280.00	-5.88
18	SUU	СҮҮ	47,238	10,790,133.96	239.00	223.00	-2.16	-0.94
19	MDR	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	35,804	7,296,590.00	220.00	200.00	-50.00	-20.00
20	BDS	БИ ДИ СЕК	6,068	5,818,038.00	1,000.00	930.00	-61.23	-6.12



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2018.11.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт /%/
			2018-11-01	2018-11-30		
1	АЛТАЙН ЗАМ	22	22,740.00	60,200.00	37,460.00	164.73
2	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	206,884	580.00	920.00	340.00	58.62
3	ХОРИН ХОЁРДУГААР БААЗ	2,750	287.50	379.00	91.50	31.83
4	ЖЕНКО ТУР БЮРО	14,953	61.00	75.00	14.00	22.95
5	ХАРХОРИН	34	1,400.00	1,700.00	300.00	21.43
6	ХУРТАЙ	105	110.00	126.50	16.50	15.00
7	ХҮРД	24	1,851.00	2,128.00	277.00	14.96
8	БАГАНУУР	1,165	1,500.00	1,679.00	179.00	11.93
9	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	6,941	90.00	100.00	10.00	11.11
10	ЖИНСТ-УВС	67,826	1,611.00	1,783.00	172.00	10.68
11	АВТО ИМПЕКС	62	1,900.00	2,099.00	199.00	10.47
12	АРД ДААТГАЛ	435,236	703.33	774.65	71.32	10.14
13	ОЛЛОО	5,001	50.00	55.00	5.00	10.00
14	ИХ БАРИЛГА	14	3,200.00	3,499.00	299.00	9.34
15	МОНГОЛ САВХИ	482	505.00	550.00	45.00	8.91
16	МОНГОЛ ШУУДАН ХК	42,377	539.99	585.00	45.01	8.34
17	ХАЙ БИ ОЙЛ	21,596,107	49.00	53.00	4.00	8.16
18	ЭРДЭНЭ ГЕСУРС	292,485	550.24	590.00	39.76	7.23
19	МОГОЙН ГОЛ	84	6,325.00	6,405.00	80.00	1.26
20	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	10	103,000.00	104,300.00	1,300.00	1.26

Ханшийн бууралттай хувьцаа

/2018.11.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2018-11-01	2018-11-30		
1	МОНИНЖБАР	101,351	180.00	90.00	-90.00	-50.00
2	ОРХОНДАЛАЙ	42	3,565.00	2,400.00	-1,165.00	-32.68
3	МОНГОЛ НЭХМЭЛ	81	2,850.00	2,100.00	-750.00	-26.32
4	МАТЕРИАЛИМПЕКС	531	10,000.00	7,435.00	-2,565.00	-25.65
5	ДӨРВӨН-УУЛ	22	1,955.00	1,500.00	-455.00	-23.27
6	ХӨХ ГАН	270,895	93.99	75.00	-18.99	-20.20
7	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	35,804	250.00	200.00	-50.00	-20.00
8	РЕМИКОН	1,360,067	32.10	26.00	-6.10	-19.00
9	ТАВАН ТОЛГОЙ	15,522	7,650.00	6,500.00	-1,150.00	-15.03
10	ТАХЬ-КО	51	12,000.00	10,200.00	-1,800.00	-15.00
11	ШИВЭЭ ОВОО	281	2,000.00	1,710.00	-290.00	-14.50
12	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	1,113	105.00	90.00	-15.00	-14.29
13	ЭРДЭНЭТ АВТО ЗАМ	2	595.00	515.00	-80.00	-13.45
14	БҮТЭЭЛЧ ҮЙЛС	10	1,500.00	1,300.00	-200.00	-13.33
15	ГУТАЛ	4	19,600.00	17,000.00	-2,600.00	-13.27



“ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЖУРАМ”-ЫН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ БАТЛАМЖЛУУЛАХААР СЗХ-НД ХҮРГҮҮЛЛЭЭ

Сүүлийн жилүүдэд Монголын хөрөнгийн зах зээлд шинээр үнэт цаас гаргах үйл явц идэвхжиж, зах зээлийн нөхцөл байдал ихээр өөрчлөгдөж байгаатай холбогдуулан 2009 онд батлагдсан МХБ-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ыг МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 2018/15 тоот тогтоолоор шинэчлэн баталж, тус журмыг батламжлуулахаар 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр СЗХ-нд хүргүүлээ.

Тус шинэчилсэн найруулгаар хөрөнгө оруулагчдаас захиалга хүлээн авах арга тус бүрийн онцлогийг харгалзан үнэ тогтоох, хуваарилалт хийх зарчмыг олон улсын нийтлэг жишигт нийцүүлсний зэрэгцээ бусад журмуудтай давхацсан зохицуулалтуудыг хасч, практик хэрэглээнд нийцүүлэх өөрчлөлтүүдийг оруулсан болно. Тухайлбал, тухайн нийтэд санал болгож буй үнэт цаасны 50 хүртэлх хувийг стратегийн хөрөнгө оруулагчид хуваарилах эрхийг андеррайтерт олгох, захиалгын бүртгэлийн аргын үед үнийн дээд, доод хязгаарыг тогтоож, үнэт цаасны эрэлтээс шалтгаалан энэхүү хязгаарыг нэг удаа өөрчлөх байдлаар үнийн уян хатан нөхцөлийг хэрэгжүүлэх зэрэг нэмэлт өөрчлөлтүүд үүнд багтах юм.

Энэхүү журамд зах зээлийн оролцогчдын саналыг нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах замаар тусгасан бөгөөд зах зээлийн хэмжээнд нэгдсэн байр суурьтайгаар дэмжсэн болно.

МХБ-Д ШИНЭЭР ХОЁР ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИ ГИШҮҮНЭЭР ЭЛСЛЭЭ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 2018/14 тоот тогтоолоор "Централ Секюритиз УЦК" ХХК болон "Инвектор капитал УЦК" ХХК-ийг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн гишүүнээр элсүүлээ.

"Централ Секюритиз УЦК" ХХК нь үнэт цаасны зах зээлд брокерийн, "Инвектор капитал УЦК" ХХК нь брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй бөгөөд тус хоёр компани гишүүнээр элссэнээр МХБ-ийн гишүүн компанийн тоо 61-д хүрлээ.

ЭРДЭНЭТ ХОТОД ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор “Үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөг” ээлжит орон нутгийн арга хэмжээг "Эрдэнэс тавантолгой" ХК болон үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран 2018 оны 11 дүгээр сарын 14-18-ны өдрүүдэд Орхон аймагт зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр хөрөнгийн зах зээлийн суурь

ойлголтууд, хувьцаа, бондын арилжаанд хэрхэн оролцох, хөрөнгийн зах зээлээс компаниуд санхүүжилт татах боломж зэрэг сэдвээр сургалт явуулснаас гадна "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагаа, иргэдэд олгосон хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, 1991 оны хөрөнгө оруулалтын эрхийн бичигтэй /ягаан цэнхэр тасалбар/ холбоотой дансны мэдээллийг тухайн аймгийг хариуцсан "БиДиСек УЦК" ХК-ийн мэдээллийн сангаас шүүх, ногдол ашгийн мэдээллийг өгөх, үнэт цаасны данс нээх, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зэргээр нийт 4,000 гаруй иргэдэд нэг цэгийн цогц үйлчилгээг үзүүллээ. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь дараагийн нээлттэй өдөрлөг арга хэмжээг зүүн аймгуудад зохион байгуулахаар төлөвлөж байна.

"ЦЕМЕНТ ШОХОЙ" ХК-ИЙН ХААЛТТАЙ ХҮРЭЭНД НЭМЖ ГАРГАСАН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ АМЖИЛТТАЙ БОЛСОНД ТООЦОЖ, ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд бүртгэлтэй Хөтөлийн "Цемент Шохой" ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 6 сая ширхэг энгийн хувьцааг хаалттай хүрээнд санал болгон гаргахыг СЗХ-ны 2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 316 тоот тогтоолоор зөвшөөрсний дагуу тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр явагдаж, нэмж гаргаж буй үнэт цаасыг нэг бүрийг нь 170 төгрөгөөр амжилттай арилжсан болно.

Үүний дагуу, СЗХ-ноос тус компанийн нэмэлт үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 1/4380 тоот албан бичгээр олгосон тул "Цемент шохой" ХК-ийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс нээлээ.

“МАТЕРИАЛ ИМПЕКС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Материал импекс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2018 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн 63.54 хувийн ирцтэйгээр хуралдсан бөгөөд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид 100 хувь зөвшөөрсний дагуу “Материал кредит” ХХК-ийг үүсгэн байгуулж, түүнтэй холбогдох өөрчлөлтүүдийг компанийн дүрэмд тусгахаар шийдвэрлэсэн байна.



"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН" ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУДАД ТАНИЛЦУУЛГА ХИЙЛЭЭ

"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" (TSX:ERD| MSE:ERDN) нь компанийн үйл ажиллагааны тайлан, цаашдын төлөвлөгөөний талаар 2018 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны компаниудад танилцууллаа.

Тус компани нь 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Баян Хөндий алтны ордын NI 43-101 эрдсийн нөөцийн тайланг Канад улсын SEDAR буюу тайлан бүртгэлийн цахим системд оруулж, нийтэлсэн бөгөөд энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн билээ.

Танилцуулгын үеэр Гүйцэтгэх захирал Петер Акерли

"Бид хөндий алтны төслийг ашиглалтын түвшинд хөгжүүлэхээс гадна шинээр илрүүлсэн алтны дүүрэгт

шинэ ордууд илрүүлэх, одоогийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хайгуулын хөтөлбөрийг үргэлжлүүлнэ. Алтан Сум, ХойдХөндийн хайгуулын хөтөлбөрөөс гадна манай техникийн баг Монгол улсын баруун өмнөд бүсийн боломжит хайгуулын талбайнуудад хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар авах боломжуудыг судалж байна" гэж мэдэгдлээ.

Түүнчлэн, тус компани дотоодын хувьцаа эзэмшигчдэд зориулан өөрийн цахим хуудасны Монгол хэл дээрх хувилбарыг ашиглалтанд оруулсан тул хөрөнгө оруулагчид www.erdene.com цахим хуудсанд зочлон компанийн талаарх мэдээллийг цаг алдалгүйгээр баталгаат эх үүсвэрээс авах боломжтой болсон байна.

ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ КОМПАНИУДЫН АНХААРАЛД

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 23.11.3-т зааснаар бүртгэлтэй байх хугацаанд тогтмол биелүүлэх үүрэг болон хууль, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, жилийн үйлчилгээний хөлсийг 2 жилээс дээш хугацаанд төлөөгүй компаниудын үнэт цаасыг Биржийн бүртгэлээс хасахаар тусгасан байдаг.

Сүүлийн 3 жилийн хугацаанд журам болон гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй, жилийн үйлчилгээний хөлсөө 2 буюу түүнээс дээш жил төлөөгүй 99 ХК байгаа бөгөөд тэдгээр компаниуд Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс хасагдах нөхцөл үүссэн тул холбогдох журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, журмын шалгуур, шаардлагыг хангаж ажиллахыг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн зүгээс тус компаниудад анхааруулж байна. Компанийн дэлгэрэнгүй жагсаалтыг www.mse.mn хуудаснаас үзнэ үү.

Үйл явдал

"МАНДАЛ ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Мандал даатгал" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 18/007 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 11:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлын тов: 2018 оны 12-р сарын 12-ны 11:00 цагт

Хуралдах газар: Блю Скай зочид буудлын Кристал хурлын танхим

Бүртгэх өдөр: 2018 оны 11-р сарын 20-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, батлах;
 2. Компанийн дүрмийг хэлэлцэж, батлах
- Компанийн хувьцааг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагааны хэрэгжилт, үр дүн болон уг ажиллагаатай холбогдон гарсан зардлын тайланг танилцуулах;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцахыг хүсвэл 2018 оны 12-р сарын 1-ний өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд СБД, 1-р хороо, Сөүл рестораны баруун талд Паркплэйс оффис төвийн 3 давхарт байрлах компанийн байранд ирж танилцаж болно.

Холбоо барих утас: 75773000

"ГУРИЛ ТЭЖЭЭЛ БУЛГАН" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Гурил тэжээл булган" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах хугацаа:

2018.12.25-ны өдрийн 11:00 цагт

Бүртгэх өдөр: 2018.12.05-ны өдөр

Хуралдах газар: ХУД, 15-р хороо Чингисийн өргөн чөлөө, "Бэрэн групп" ХХК-ийн хурлын зааланд

Хурлаар хэлэлцэх асуудал: "Гурил тэжээл булган" ХК-ийн өмчлөлийн 000097126 тоот гэрчилгээтэй, Улсын бүртгэлийн Y-0405000525 дугаарт бүртгэгдсэн, Булган аймгийн Булган сумын 5-р багт байршилтай үл хөдлөх хөрөнгийг иргэн Б. Сарангэрэл /РД: ЧВ64042201/-ийн өмчлөлд шилжүүлэх тухай

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг: Ажлын өдрүүдэд 9:00-17:00 цагийн хооронд ХУД-ийн 15-р хороо, "Бэрэн групп" ХХК-ийн байранд ирэх эсхүл харилцагч брокерын компаниас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Хурал зохион байгуулах коммис: 88035353



"ХАЙ БИ ОЙЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Хай Би Ойл" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 9 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 10:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлын тов: 2018 оны 12-р сарын 10-ны 10:00 цагт

Хуралдах газар: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Баянгол зочид буудлын хурлын танхим

Бүртгэх өдөр: 2018 оны 11-р сарын 19-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал: Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, батлах;

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцахыг хүсвэл ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд СХД, 20 дугаар хороо, Сонсголонгийн /18135/-110 компанийн байранд ирж танилцаж болно.

Холбоо барих утас: 89894533, 99096952

"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН"- ЭЭС ИРҮҮЛСЭН МЭДЭГДЭЛ

Монголын хөрөнгийн бирж дээр үнэт цаасаа давхар бүртгүүлсэн "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" (TSX:ERD| MSE:ERDN) нь Монгол Улсад Баян Хөндий, Алтан нар орд газарт алтны хайгуулын үйл ажиллагаа явуулах "Хөндий" нэртэй төслийг хэрэгжүүлдэг бөгөөд тус компани нь Баян Хөндий алтны ордын NI 43-101 эрдсийн нөөцийн тайланг Канад улсын SEDAR буюу тайлан бүртгэлийн цахим системд оруулж, нийтэлсэн тухайгаа 2018 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр мэдээллээ.

Тус компани нь Хөндий төслийн эдийн засгийн урьдчилсан үндэслэл, тооцоолол болон Баян Хөндий, Алтан нар орд газарт ашиглалтын тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргасантай холбогдуулан шаардлагатай техникийн судалгаануудыг 2018 оны 4 улиралд тус тус хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

"ШАРЫН ГОЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Шарын гол" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 33 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах хугацаа:

2018.12.26-ны өдрийн 13:00 цагт

Бүртгэх өдөр: 2018.12.05-ны өдөр

Хуралдах газар: Улаанбаатар зочид буудлын хурлын зааланд

Хурлаар хэлэлцэх асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг: Ажлын өдрүүдэд 9:00-17:00 цагийн хооронд Дархан-Уул

аймгийн Шарын гол суманд байрлах компанийн байранд ирэх эсхүл харилцдаг брокерын компаниас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Хурал зохион байгуулах комисс: 88026677, 99293913, 70372235

"ЦЕМЕНТ ШОХОЙ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Цемент шохой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 18/62 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах хугацаа:

2018.12.25-ны өдрийн 10:00 цагт

Бүртгэх өдөр: 2018.12.07-ны өдөр

Хуралдах газар: Сэлэнгэ аймаг, Сайхан сум, "Цемент шохой" ХК-ийн хурлын зааланд

Хурлаар хэлэлцэх асуудал:

Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах; Компанийн тухай хууль болон Компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

Сэлэнгэ аймаг, Сайхан суманд байрлах "Цемент шохой" ХК-ийн байранд ирэх эсхүл харилцдаг брокерын компаниас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу. **Хурал зохион байгуулах комисс:** 99144535, 99683422, 94736330

"ЭРДЭНЭТ ЗАНДАН" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Эрдэнэт зандан" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 01 тоот шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах хугацаа: 2018.12.12-ны өдрийн 10:00 цагт

Бүртгэх өдөр: 2018.11.27-ны өдөр

Хуралдах газар: Орхон аймаг, Говил баг, Эрдэнэт Зандах ХК-ийн үйлдвэрийн байр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. "Эрдэнэт Зандан" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгож, Төлөөлөн удирдах зөвлөлийг шинээр байгуулах тухай;
 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын, Цалин урамшууллын, Нэр дэвшүүлэх хороодыг байгуулах тухай; ТУЗ-ийн дэргэдэх хороодод гишүүдийг томилох тухай;
 3. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх гүйцэтгэх удирдлагын дүгнэлт бүхий тайлан;
 4. Компанийг өөрчлөн байгуулах төсөл;
 5. Хараат бус үнэлгээний байгууллагаар хийлгэсэн компанийн бизнесийн үнэлгээ;
 6. Нэгж хувьцааг эргүүлэн авах үнэ;
 7. "Эрдэнэт зандан" ХК-ийн дүрмийн төсөл;
 8. Компанийг өөрчлөн байгуулахтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журам.
- Дэлгэрэнгүй мэдээллийг: 99011106**

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN